

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас:99422227 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек


Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Р.Содномдаржаа

Утас: 88031333 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgi@audit.gov.mn	ЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАРКИНГҮЛ ТАНАА
2026.02.25 № 212 танай _____ -ны № _____ -т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2025 онд 6,509.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 6,240.7 сая төгрөг зарцуулж, 95.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь каргалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.</p>	
832605000175	

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ



Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,509,901,900.00	6,240,693,093.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,509,901,900.00	6,240,693,093.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,166,248,800.00	5,936,909,193.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,665,463,000.00	4,569,485,140.00
210101	Үндсэн цалин	2,840,779,000.00	2,560,574,340.00
210102	Нэмэгдэл	1,688,480,100.00	1,794,456,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		78,250,000.00
210104	Урамшуулал	136,203,900.00	136,203,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	657,079,400.00	626,522,800.00
210201	Тэтгэврийн даатгал	446,814,000.00	419,735,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	52,566,300.00	51,697,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,283,200.00	25,848,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	26,283,200.00	25,848,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	105,132,700.00	103,393,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	327,247,000.00	326,247,000.00
210301	Гэрэл, цахилгаан	19,457,000.00	18,937,416.00
210302	Түлш, халаалт	302,790,000.00	302,309,584.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	5,000,000.00
2105	Нормативт зардал	259,591,500.00	205,058,950.00
210502	Хоол, хүнс	259,591,500.00	205,058,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,673,500.00	71,402,941.25
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	79,673,500.00	71,402,941.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,194,400.00	136,192,362.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,421,700.00	115,721,262.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,772,700.00	20,471,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	343,653,100.00	303,783,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	343,653,100.00	303,783,900.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,509,901,900.00	6,056,420,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,854,237,600.00	5,726,863,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,854,237,600.00	5,726,863,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	329,247,000.00	328,247,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	329,247,000.00	328,247,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	326,417,300.00	1,310,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,310,000.00	1,310,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	325,107,300.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		326,151,640.66
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		141,878,847.41
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	162.00	162.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	124.00	124.00
620003	Үйлчлэх ажилтан	37.00	37.00

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Гурав. Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 184.4 сая төгрөгийн 17 удаагийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг долоо хоногийн дотор мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 427.2 сая төгрөгийн орлогын 20 мөнгөн гүйлгээг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 11.8 сая төгрөгийн зарлагын 1 мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй, өр төлбөр үүсгэсэн 59.7 сая төгрөгийн 1 шийдвэр, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 668.5 сая төгрөгийн 1 шийдвэрүүдийг шилэн дансанд байршуулаагүй шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 81.7 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1-т Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны байршуулаагүй 1,351.6 сая төгрөгийн 40 мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөмж болгов.

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 2,614.0 сая төгрөгийн алдаа¹ илэрч, аудитын явцад 2,614.0 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан газрыг үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод бүртгэсэнийг залруулж төрийн өмч дансанд 3.6 сая төгрөгийг бүртгэв
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт улсын төсвөөс санхүүжих 1,956.0 сая төгрөг дутуу, орон нутгийн төсвөөс санхүүжих 329.2 сая төгрөгийг, урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 325.1 сая төгрөгийг тусгаагүй

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар санхүүгийн тайлангийн аудитын асуудалтай холбоотой нийт 8.6 сая төгрөгийн зөрчил² илэрч, 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 8.1 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгдлөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Тайланд онд нэр бүхий албан хаагчид олгосон 500.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тухайн албан хаагчаас цалингийн урьдчилгаа 0.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Түлш халаалтын зардлын төсвийн зарцуулалт, тооцоотой холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Тус сургууль нь тайлант онд халаалтын зардлын төсвөөс 258.5 сая төгрөгийг дулаанаар хангагч "Агайын" ХХК-нд төлсөн бөгөөд гэрээнд сургуулийн хичээлийн байр нь 13005 м2 дотуур байр 1, дотуур байр 2 нийт 2016 м3 талбайд батлагдсан үнэ тарифын дагуу нийтдээ 258.5 сая төгрөгийг халаалтын зардалд төлсөн ба аймгийн хэмжээнд хийгдэж байгаа барилга байгууламжийн талбайн хэмжээг шинээр хэмжих судалгаагаар үзэхэд сургуулийн байр 9498.9 м2, 1, 2-р дотуур байр 1684.11 м3 гарч байгаа бөгөөд тооцоолж үзэхэд 8.1 сая төгрөгөөр илүү төлөгдсөн байх магадлалтай байна.Энэ нь халаалтын талбайн хэмжээг баталгаажуулаагүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 зүйлийн 15.2.1-д "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг Эрчим хүчний тухай хууль болон Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 164 дүгээр тогтоолоор баталсан "Дүрэм шинэчлэн батлах тухай" дүрэмд нийцүүлэн шинэчлэн байгуулах, гэрээнд халаалт авах талбайн хэмжээ, төлбөрийн мөнгөн дүнг тодорхой тусгаж, халаалтын зардлын төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агуй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогыг залруулав	1	3,564.0			1	3,564.0	1	3,564.0				
ТГ-ийн тайланд орлого дутуу авсан	1	2,610,399.5	1	2,610,399.5			1	2,610,399.5				
Дүн	2	2,613,963.5	1	2,610,399.5	1	3,564.0	2	2,613,963.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Суутгаж аваагүй урьдчилгаа цалин	1	500.0	1	500.0								
Халаалтын тооцооны зөрүү	1						1	8,082.0				
Дүн	2	8,582.0	1	500.0			1	8,082.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 1,351.6 сая төгрөгийн мэдээлэл байршуулаагүй мэдээлсэн байдлын хэрэгжилт 81.7 хувь байна.	1	1,351,651.6					1	1,351,651.6
Дүн	1	1,351,651.6					1	1,351,651.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								